

БАТЛАВ

НЖДУУДТ НӨҮГ-ЫН  
дарга

Х.Отгонзул



БАТЛАВ

ЮНЕСКО-ийн МҮК-ийн  
Ерөнхий нарийн бичгийн  
дарга

С.Болдсайхан



БАТЛАВ

СУИС-ийн  
Ректор

Э.Сонинтогос



## “БҮТЭЭЛЧ ОЮУТАН” ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

Улаанбаатар хот

2024.10.22

**Үндэслэл:** Дэлхийн 10 гаруй улсаас 358 хот ЮБХС-нд нэгдэж өөр хоорондоо бүтээлч салбараар хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлж байна. Улаанбаатар хот 2023 онд гар урлал ба ардын урлагийн төрлөөр ЮБХС-нд (*ЮНЕСКО-ийн бүтээлч хотын сүлжээнд*) албан ёсоор нэгдэн орсон бөгөөд энэ хүрээнд бүтээлч 7 салбарт /кино, хөгжим, гар урлал ба ардын урлаг, дизайн, хоолны урлаг, утга зохиол, медиа арт/ хамтын ажиллагааг үүсгэж хотын эдийн засгийн хөгжилд тодорхой үр дүн гаргах, бодлого, төлөвлөлтөд хотын иргэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх цаашлаад эдийн засгийг төрөлжүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг чадавхжуулах зэрэг олон талын ач холбогдолтой арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Бүтээлч үйлдвэрлэлд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдний санал, санаачилгыг дэмжих нь чухал ач холбогдолтой бөгөөд энэ хүрээнд Улаанбаатар хотын зүгээс “Бүтээлч оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

**Зорилго:** “Бүтээлч оюутан” хөтөлбөр нь их, дээд сургуулиудтай хамтран бүтээлч салбаруудын хүрээнд оюутан залуусын чадварыг хөгжүүлэх, тэдний санал, санаачилгыг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх зорилготой. Хөтөлбөрийн хүрээнд дотоодын болон олон улсын түвшний хамтын ажиллагааг хөгжүүлж, бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Хөтөлбөрт дараах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

- **Чадвар хөгжүүлэлт:** Оюутан залуусын бүтээлч чадварыг хөгжүүлэх
- **Санал санаачилга дэмжих:** Оюутнуудын бүтээлч санаачилгыг дэмжих, санхүүгийн болон мэргэжлийн зөвлөгөө өгөх
- **Оролцоог нэмэгдүүлэх:** Оюутнуудын идэвхтэй оролцоог нэмэгдүүлж, тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжих
- **Хамтын ажиллагаа:** Дотоодын болон олон улсын түвшний хамтын ажиллагааг хөгжүүлэх, туршлага солилцох
- **Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх:** Бүтээлч үйлдвэрлэлээр эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, оюутнуудын бүтээлч санаачилгыг зах зээлд нэвтрүүлэх

**Хамрах хүрээ:** Их дээд сургуулиудын доорх 7 салбар чиглэлээр суралцаж байгаа 3-4 курсын оюутан залуус хамрагдана. Үүнд:

- Уран зохиол (Literature)
- Хөгжмийн урлаг (Music)
- Кино урлаг (Film)
- Дизайн урлаг (Design)
- Хоолны урлаг (Gastronomy)
- Технологийн урлаг (Media Arts)
- Гар урлал болон ардын урлаг (Craft and Folk Art)

**Хөтөлбөр хэрэгжих үе шат:**

№	Үе шат	Үйл ажиллагаа	Хугацаа	Тайлбар
<b>Хөтөлбөрийн оролцогч оюутануудыг 10 сарын 23-наас 30 хүртэл бүртгэнэ.</b>				
1	Сургалт, Зөвлөх үйлчилгээнд хамруулах	<ol style="list-style-type: none"> <li>1. Бүтээлч хотуудын сүлжээний талаарх ойлголт, ач холбогдол</li> <li>2. Бүтээлч салбарын олон улсын зах зээл</li> <li>3. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжил, үзэл баримтлал</li> <li>4. Төсөл боловсруулалтын онол, арга зүй</li> <li>5. Төслийн боловсруулалтын зөвлөх үйлчилгээ</li> </ol>	2024.11.01-11.15	Бүртгэлийн дагуу 11/01-11/15-ныг хүртэл "Бүтээлч үйлдвэрлэл"-ийн сургалт, зөвлөх үйлчилгээнд оролцогчдыг хамруулна.
2	Төсөл хүлээж авах	Төслийн саналыг файлаар хүлээн авах	2024.11.15-12.14 хүртэл	2024 оны 12 сарын 14 хүртэл хүлээж авна. Энэ хугацаанд зөвөлгөө мэдээллийг 2-3 удаа өгнө.
3	Төслийн сонгон шалгаруулалт	Төслийн эхний сонгон шалгаруулалт	2024 оны 12.16	Нийт ирсэн төслөөс 30 оюутаны төслийг шалгаруулна.
		Төслийн II шатны сонгон шалгаруулалт	2024 оны 12.21	Оюутанууд төслөө танилцуулж шүүгчдийн саналын дагуу 14 төсөл шалгаруулж урамшуулал олгоно.
		Төслийн сүүлийн шатны сонгон шалгаруулалт	2025 оны 4 сард	2 дахь шатанд тэнцсэн 14 төслөөс шилдэг 7 төслийг шалгаруулж оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах эрх нээгдэнэ.
4	Туршлага солилцох аялал зохион байгуулах	2 дахь шатны сонгон шалгаруулалтаар тэнцсэн оюутан залуусыг бүтээлч хотын сүлжээнд нэгдсэн Азийн хотууд руу туршлага судлах аялалд хамруулах	2025 оны 2-3 сард	2 дахь шатанд тэнцсэн 14 оюутан хамрагдана.
5	Оюутан солилцооны хөтөлбөрийг эхлүүлэх	Бүтээлч хотын сүлжээнд нэгдсэн Азийн хотуудын их, дээд сургуулиудад оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах ажлыг эхлүүлэх	2025 оны 4-6 сард	Шилдэг 7 төслийн санаачлагч нарыг оюутан солилцооны хөтөлбөрт хамруулж урамшуулах

**Хэрэгжүүлэгч байгууллага:**

- Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв НӨҮГ
- ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс
- Соёл Урлагийн Их Сургууль
- Бусад их дээд сургуулиуд

**Холбоо барих:**

Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ  
Утас: 11-318547, 99062162, 88015011